



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/78

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Баатархайрхан баг Д.Санжжавын 1 дүгээр гудамжны 125 тоотод байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай "Хөхийн цөгц" ХХК /4063902/-ийн эзэмшлийн 7344 метр квадрат газраас 5230 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Лувсангийн Уранчимэг /ПЮ70101960/-д шилжүүлж, хаягийг Д.Санжжавын 1 дүгээр гудамжны 125 а тоот болгон, худалдаа, үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар, үлдсэн 2114 метр квадрат газрыг "Хөхийн цөгц" ХХК /4063902/-д хаягийг Д.Санжжавын 1 дүгээр гудамжны 125 тоот болгон 46 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Магсаржав баг 4 дүгээр гудамжны 6 тоотод байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Нямаагийн Жамъяндорж /ПЮ67112012/-ийн эзэмшлийн 390 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Дагванамжилын Батболд /ПП79102513/-д шилжүүлж, хаягийг Амарсанаагийн 5 дугаар гудамжны 503 тоот болгон 4 жилийн хугацаагаар,


3. Жаргалант сумын Цамбагарав баг 09 дүгээр гудамжны 09 тоотод байрлах орон сууцны зориулалттай Дашзэвэгийн Лхамсүрэн /МД58102575/-ийн эзэмшлийн 2480 метр квадрат газраас 222.0 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу "Хишиг бүрэн" ХХК /4061284/-д шилжүүлж, хаягийг Ану хатан 2 дугаар гудамжны 205 в тоот болгон, худалдаа, үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар, 157.0 метр квадрат газрыг Дашзэвэгийн Лхамсүрэн /МД58102575/-д шилжүүлж, хаягийг Ану хатан 2 дугаар гудамжны 205 г тоот болгон, худалдаа, үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар

шилжүүлэн эзэмшүүлж, үлдсэн 2101 метр квадрат газрыг нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.

4. Эзэмшил газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлэхийг дээрх иргэн, аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

5. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ